

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй.

1/7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэг:

“7.4.Засгийн газар энэ хуулийн 13.2-т заасан төсөлд төлбөрийн үүрэг хариуцлага хүлээхгүй.”

2/11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэг:

“11.4.Энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.5, 11.2.6-т зааснаар хэрэгжүүлэх түншлэлийн төсөл, хөтөлбөрт улсын төсвөөс санхүүжилт олгохгүй.”

3/12 дугаар зүйлийн 12.2.12, 12.2.13, 12.2.14 дахь заалт:

“12.2.12.салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл болон хувийн хэвшлээс санаачилсан төслийн саналыг хүлээн авах;

12.2.13.энэ хуулийн 13.2-т заасан түншлэлийн төсөл, гэрээг бүртгэх, бүртгэлийн нэгдсэн сан бүрдүүлэх;

12.2.14.хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллах.”

4/18 дугаар зүйлийн 18.2.17 дахь заалт, 18.4 дэх хэсэг:

“18.2.17.дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн байх;

18.4.Энэ хуулийн 5.1.13-д заасан үйлчилгээ үзүүлэх төсөлд техник, эдийн засгийн үндэслэл шаардахгүй бөгөөд мөнгөний үнэ цэнийн шинжилгээ, төсөвт үзүүлэх нөлөөллийн шинжилгээ, эрсдэлийн шинжилгээ, хууль зүйн дүн шинжилгээ болон нийгмийн нөлөөллийн шинжилгээг хийнэ.”

5/30 дугаар зүйлийн 30.5 дахь хэсэг:

“30.5.Түншлэлийн төслийн санхүүжилт, түүнтэй холбоотой үүсэх ханшийн эрсдэлийг талууд хэрхэн хуваарилах талаар түншлэлийн гэрээнд тодорхой тусгана.”

6/31 дүгээр зүйлийн 31.6 дахь хэсэг:

“31.6.Энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.5, 11.2.6-т зааснаар хэрэгжүүлэх түншлэлийн төсөл, хөтөлбөрт Засгийн газрын баталгаа хамаарахгүй.”

7/32 дугаар зүйлийн 32.5, 32.6 дахь хэсэг:

“32.5.Энэ хуулийн 32.1.4-т заасан санхүүжилтийг олгохдоо, түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн

захиргааны төв байгууллагад төсвийн санал хүргүүлэх үеийн ханшаар тооцоолж төслийг санхүүжүүлнэ.

32.6.Тухайн жилийн төсвийн санал хүргүүлэх үеийн ханш болон хувийн хэвшлийн түншлэгчид батлагдсан санхүүжилтийг олгох үеийн ханшийн зөрүүнээс үүсэх ашиг, алдагдлыг төрийн түншлэгч хариуцахгүй.”

8/40 дүгээр зүйлийн 40.2.4 дэх заалт, 40.6 дахь хэсэг:

“40.2.4.хувийн хэвшлийн түншлэгч түншлэлийн төслийг гэрээнд заасан хугацаанд дуусган, хүлээлгэж өгөөгүй;

40.6.Энэ хуулийн 40.2.4-т зааснаар гэрээг цуцалснаас үүсэх аливаа хохирлыг хувийн хэвшлийн түншлэгч хариуцна.”

9/50 дугаар зүйлийн 50.2.6 дахь заалт:

“50.2.6.төслийн бүрэн шинжилгээ хийх төслийн баг, төслийн сонгон шалгаруулалтын ажлын хэсэгт ажиллах гишүүдийн урамшуулал;”

10/54 дүгээр зүйлийн 54.4 дэх хэсэг:

“54.4.Энэ хуулийн 54.1-т заасан хяналтыг төрийн түншлэгч тухайн салбарын мэргэжлийн байгууллагаар хийлгэж болох бөгөөд мэргэжлийн байгууллагын буруутай үйл ажилласны улмаас талуудад учирсан хохирлыг мэргэжлийн байгууллага өөрөө бүрэн хариуцна.”

2 дугаар зүйл. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 1 дүгээр 1.1 дэх хэсэг, 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “салбарт” гэсний дараа “болон Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн зорилго, зорилтод нийцсэн төсөл хөтөлбөрийг” гэж, 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн “Түншлэлийн” гэсний дараа “төв” гэж, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “байгууллага” гэсний дараа “нь түншлэлийн төв болон” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалт:

“8.1.3.энэ хуулийн 20.4-т заасан төслийн бүрэн шинжилгээг хянаж, санал, дүгнэлт гарган, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал, дүгнэлтийн хамт Засгийн газраар хэлэлцүүлэх;”

2/9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.1.5 дахь заалт:

“9.1.4.Түншлэлийн төвөөс ирүүлсэн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээнд үндэслэн төсвийн эрсдэл, төсөвт үзүүлэх нөлөөлөл болон хөрөнгийн эх үүсвэрийг хянаж, санал, дүгнэлтээ түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

9.1.5.түншлэлийн гэрээний төсөлтэй танилцаж, төсөвт үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийн шинжилгээг хянах, түншлэлийн гэрээ байгуулах болон түншлэлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахад холбогдох санал, дүгнэлтээ түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;”

3/10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт:

“10.1.1.түншлэлийн төслийн саналаа түншлэлийн төвд хүргүүлэх;”

4/11 дүгээр зүйлийн 11.2.2 дахь заалт:

“11.2.2.энэ хуулийн 13.2.1-13.2.6-д зааснаас бусад салбарт хэрэгжүүлэх 100 тэрбум төгрөгөөс дээш өртөгтэй түншлэлийн төслийн саналаа түншлэлийн төвд хүргүүлэх;”

5/12 дугаар зүйлийн 12.2.4 дэх заалт:

“12.2.4.Энэ хуульд зааснаар түншлэлийн төслийн бүрэн шинжилгээг салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран хийж, түншлэлийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;”

6/13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг:

“13.2.Аймаг, нийслэл дараах салбарт түншлэлийн төслийг хэрэгжүүлж болно:”

7/15 дугаар зүйлийн 15.1.10 дахь заалт:

“15.1.10. Барих, ашиглах, өмчлөх;”

8/20 дугаар зүйлийн 20.4, 20.5 дахь хэсэг:

“20.4.Төслийн баг холбогдох аргачлал, журмын дагуу дараах байдлаар тухайн төслийн хэрэгцээ, шаардлага, санхүү, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, төсөвт үзүүлэх нөлөөлөл, эрсдэл, санхүүгийн болон бусад нөөц, боломжийг бүрэн шинжилгээгээр тодорхойлж дүгнэлт гаргана:

20.4.1.техник, эдийн засгийн үндэслэл;

20.4.2.төслийг хэрэгжүүлэх түншлэлийн төрөл, түншлэлийн гэрээний төрөл, загвар, гол нөхцөл;

20.4.3.төслийн эрсдэл, түүнийг бууруулах арга хэмжээг тодорхойлсон эрсдэлийн шинжилгээний дүгнэлт.

20.5.Энэ хуулийн 20.4.1-т заасан техник, эдийн засгийн үндэслэлд тухайн төсөлд шаардлагатай төрөөс үзүүлэх дэмжлэгийн төрлөөс гадна дараах шинжилгээ багтана:

20.5.1.мөнгөний үнэ цэнийн шинжилгээ;

20.5.2.төсөвт үзүүлэх нөлөөллийн шинжилгээ;

20.5.3.хууль зүйн дүн шинжилгээ, нийгмийн болон байгаль орчны нөлөөллийн шинжилгээ.”

9/21 дүгээр зүйлийн 21.1, 21.6 дэх хэсэг:

“21.1.Түншлэлийн төв нь түншлэлээр хэрэгжүүлэхэд тохиромжтой гэж тодорхойлсон төслийг төслийн иж бүрэн баримт бичгийн хамт түншлэлийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүрэн шинжилгээ хийгдэж, дүгнэлт гарснаас хойш ажлын 5 өдөрт багтаан хүргүүлнэ.

21.6.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага түншлэлийн төслийн саналыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал, дүгнэлтийн хамт Засгийн газарт хүргүүлнэ.”

10/25 дугаар зүйл:

“25.1.Хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулахад дараах үйл ажиллагааг зохион байгуулна:

25.1.1.ажлын хэсэг сонгон шалгаруулалтын баримт бичиг, түншлэлийн гэрээний загвар, шалгуур үзүүлэлтийг холбогдох журмын дагуу боловсруулж, түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулна.

25.1.2.сонгон шалгаруулалтын баримт бичигт холбогдох журамд зааснаас гадна дараах мэдээллийн талаарх шалгуур үзүүлэлтийг тусгана:

25.1.2.а.түншлэлийн төслийн танилцуулга, төслийн ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, жишиг маягт, төсөл хэрэгжүүлэх төрийн түншлэгчийн талаарх мэдээлэл, тайлбар;

25.1.2.б.түншлэлийн төслийн гол хүчин зүйл, хувийн хэвшлийн түншлэгчийн үзүүлэх үйлчилгээ, төрөөс үзүүлэх дэмжлэгийн тухай мэдээлэл;

25.1.2.в.төслийг хэрэгжүүлэхэд хувийн хэвшлийн түншлэгчийн санхүү, удирдлага, хүний нөөцийн чадавх, ижил төстэй төсөл хэрэгжүүлсэн туршлага;

25.1.2.г.түншлэлийн гэрээний гол нөхцөл;

25.1.2.д.оролцогчид тавих шаардлага;

25.1.2.е.сонгон шалгаруулалтын шалгуур болон шалгаруулах арга хэлбэр, аргачлал, оролцогчид өгөх заавар, баримт бичиг илгээх хэлбэр, хугацаа;

25.1.2.ё.шаардлагатай бусад баримт бичиг, мэдээлэл.

25.1.3.ажлын хэсэг сонгон шалгаруулалтын баримт бичиг, түншлэлийн гэрээний загварыг боловсруулж эрх бүхий этгээдээр батлуулснаас хойш оролцогчдод баримт бичиг, гэрээний загварыг олгоно;

25.1.4.сонгон шалгаруулалтад оролцогч, ажлын хэсэг, төрийн түншлэгч байгууллага, санхүүжүүлэгч болон төсөлд хамаарах этгээдийн төлөөллөөс бүрдсэн тодруулга уулзалт, хэлэлцүүлгийг баримт бичиг олгосноос хойш зохион байгуулах;

25.1.5.сонгон шалгаруулалтад оролцогч гэрээний нөхцөлийг тусгасан төслийн баримт бичгийг энэ хууль, холбогдох журмын дагуу боловсруулан, баримт бичиг олгосон өдрөөс хойш 1 сараас доошгүй хугацаанд ажлын хэсэгт саналаа ирүүлэх;

25.1.6.ажлын хэсэг хувийн хэвшлээс ирүүлсэн саналыг үнэлж, хамгийн сайн нөхцөлтэй саналаас эхлэн дараалуулах байдлаар сонгон шалгаруулах;

25.1.7.сонгон шалгаруулалтын саналыг үнэлэх, оролцогчид мэдэгдэл хүргүүлэх;

25.1.8.ажлын хэсэг нь шалгарсан оролцогчтой гэрээний нөхцөлийн талаар хэлэлцээр хийх;

25.1.9.Засгийн газрын шийдвэрийн дагуу хувийн хэвшлийн түншлэгчтэй гэрээ байгуулах, олон нийтэд мэдээлэх.

25.2.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон хувийн хэвшлийн оролцогч талууд төслийн хэрэгцээ, шаардлагыг өөрчлөх, сайжруулах шаардлагатай гэж харилцан тохиролцсон тохиолдолд түншлэлийн төслийн энэ хуулийн 25.1.2-т заасан мэдээлэлд дурдсан үндсэн шаардлага, талуудын хооронд байгуулсан гэрээний гол нөхцөлийг өөрчлөхгүйгээр төслийн баримт бичгийг дахин боловсруулж болно.

25.3.Төслийн саналын баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн, эсхүл бүрдэл дутуу ирүүлсэн нь оролцогчийн төслийн саналыг буцаах үндэслэл болно.”

11/26 дугаар зүйлийн 26.4, 26.5 дахь хэсэг:

“26.4.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь сонгон шалгаруулалт, түншлэгчтэй хийсэн хэлэлцээний дүн, ажлын хэсгийн дүгнэлтийг төсөвт үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийн талаас хянаж, санал, дүгнэлтээ ажлын 10 өдөрт багтаан Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

26.5.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага түншлэлийн гэрээ байгуулах тухай санал, дүгнэлтээ Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлсэн санал, дүгнэлтийн хамт Засгийн газарт танилцуулан түншлэлийн гэрээ байгуулах эсэх шийдвэрийг гаргуулна.”

12/35 дугаар зүйлийн 35.2.37 дахь заалт:

“35.2.37.түншлэлийн гэрээний санхүүжилт, түүнтэй холбоотой ханшийн эрсдэлийг энэ хуулийн 32 дугаар зүйлд заасны дагуу тодорхойлох;”

4 дүгээр зүйл. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “түншлэлийн төслийг” гэснийг “түншлэлээр” гэж, “холбогдуулан эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд оршино.” гэснийг “холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.16 дахь заалтын “Засгийн газраар хэлэлцүүлэх зөвшөөрлийг авах” гэснийг “санал, дүгнэлт авах” гэж, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “Түншлэлийг” гэснийг “Түншлэлээр” гэж, 15 дугаар зүйлийн “15.1.10” гэсэн дугаарыг “15.1.11” гэж, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн “Түншлэлийн болон салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэснийг “Салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон түншлэлийн төв” гэж, мөн зүйлийн “20.5” гэсэн дугаарыг “20.11” гэж, 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсгийн “Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрлийг” гэснийг “холбогдох санал, дүгнэлтээ” гэж, мөн зүйлийн 21.5 дахь хэсгийн “зөвшөөрөл олгохдоо” гэснийг “санал, дүгнэлт гаргахдаа” гэж, мөн зүйлийн 21.7 дахь хэсгийн “боловсруулж” гэснийг “боловсруулсан” гэж, мөн зүйлийн 21.10 дахь хэсгийн “Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэснийг “Түншлэлийн төв” гэж, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад” гэснийг “түншлэлийн төвд” гэж, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийн “25.6.7” гэснийг “25.1.6” гэж, 35 дугаар зүйлийн “35.2.37” гэсэн дугаарыг “35.2.38” гэж, 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсгийн “зөвшөөрөлд” гэснийг “санал, дүгнэлтэд” гэж, мөн зүйлийн 39.3 дахь хэсгийн “зөвшөөрөл авч” гэснийг “санал, дүгнэлт авч” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.13 дахь заалтын “иргэдийн ая тухтай амьдрах таатай орчныг бүрдүүлэх зорилгоор дэд бүтэц, эрчим хүч, зам, тээвэр, эрүүл мэнд, боловсрол, соёл болон холбогдох бусад салбарт” гэснийг, мөн зүйлийн 5.1.16 дахь заалтын “төслийн урьдчилсан үнэлгээ” гэснийг, мөн зүйлийн 5.1.24 дэх заалтын “урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл, нарийвчилсан” гэснийг, 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтын “урьдчилсан үнэлгээ хийсэн,” гэснийг, 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалтын “урьдчилсан үнэлгээ нь хянан баталгаажсан” гэснийг, 12 дугаар зүйлийн 12.2.3 дахь заалтын “урьдчилсан үнэлгээ, урьдчилсан болон нарийвчилсан” гэснийг, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “энэ хуулийн 3.2-т зааснаас бусад салбарт” гэснийг, мөн зүйлийн 13.3 дахь хэсгийн “урьдчилсан үнэлгээ болон” гэснийг, 17 дугаар зүйлийн 17.1.1.6 дэх заалтын “урьдчилсан үнэлгээний дүгнэлтэд үндэслэн” гэснийг, мөн зүйлийн 17.1.2.6 дахь заалтын “урьдчилсан болон нарийвчилсан” гэснийг, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийн “тусгай” гэснийг, 21 дүгээр зүйлийн 21.5.1 дэх заалтын “нарийвчилсан” гэснийг, мөн зүйлийн 21.7 дахь хэсгийн “санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөл олгогдсон” гэснийг, 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсгийн “нарийвчилсан” гэснийг, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “урьдчилсан үнэлгээ хийгдэж,” гэснийг, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “урьдчилсан болон уралдаант шалгаруулалтын” гэснийг, 33 дугаар зүйлийн 33.10 дахь хэсгийн “болон энэ хуулийн

3.2-т заасан түншлэлд үл хамаарах салбарт хэрэгжих” гэснийг 39 дүгээр зүйлийн 39.1.2 дахь заалтын “нарийвчилсан” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2, 7 дугаар зүйлийн 7.2.6, 8 дугаар зүйлийн 8.1.1, 9 дүгээр зүйлийн 9.1.8, 10 дугаар зүйлийн 10.1.2, 10.1.3, 10.1.4, 17 дугаар зүйлийн 17.1.1.а, 18 дугаар зүйлийн 18.1, 19 дүгээр зүйл, 21 дүгээр зүйлийн 21.3, 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг